

№		2023 оны байдлаархи тайлан
1	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр хаяг	Төв аймгийн Барилга захиалагч орон сууцны корпораци орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төв аймаг Зуунмод сум 6-р баг Төр захиргааны 2-р байр
2	Дүрэм	
3	Үйл ажиллагааны чиглэл	1. Аймгийн орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах, аймгаас зорилтод бүлгийн иргэдийг орон сууцаар хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах.2. Улсын болон орон нутгийн төсвийн, хувийн хөрөнгө оруулалт, төрийн оролцоотой хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх барилга, байгууламжийн захиалагчийн чиг үүргийг гүйцэтгэж, хяналт хийх. 3. Барилга захиалагчийн дүрмийн дагуу аймгийн хэмжээнд хийгдэх барилгын шинэ болон засварын ажлын зураг, төсөв боловсруулах, магадлал хийлгэх, зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх.
4	Эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг алдагдлын тайлан	100 хувь орон нутгийн өмчит. Дүрмийн сан 1.000.000төгрөг 2023 оны хагас жилийн байдлаар хуримтлагдсан ашиг 71.1сая төгрөг
5	Нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	47,775,977 төгрөг /ААНОАТ, ХХОАТ, НӨАТ/
6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн	Төв аймгийн ИТХТ-н 2021.02.04-ны өдрийн 13тоот тогтоолоор дарга -1, гишүүн-4, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан.
7	Тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Дарга: Г.Сурмаа гишүүд: Д.Саран-эрдэнэ, Д.Батжаргал, Д.Алтансүх, Д.Ганбаяр



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000127417

Хууль зүйн сайдын 2016. оны

А/204 дугаар тушаалаар батлав



2017.06.08

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

1414001011

/ Хувийн хэргийн дугаар /

3871185

/ Регистрийн дугаар /

Төв аймгийн Орон сууцны корпораци

Орон нутгийн өмчит ААТҮГ

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

62

2017.05.29

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

8211

/ код /

Аймгийн орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах, аймгаас зорилтод бүлгийн иргэдийг орон сууцаар хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

1 000,0

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Төв, Зуунмод, 6-р баг, Баруун зуунмод, Төр захиргааны 2-р байр, Утас1: 98989818, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Төв аймгийн Улсын бүртгэлийн
хэлтэс

/ бүртгэсэн байгууллагын нэр /

3859467 4116129098

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэс...	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Даш овогтой Ганбаяр-а Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч-р томилсныг бүртгэв.	2017.06.08	Т.Болормаа
1	Төв аймгийн Орон сууцны корпораци' оноосон нэр 'Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци' болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2017.11.06	П.Болормаа
2	8411 Улсын болон орон нутгийн төсвийн, хувийн хөрөнгө оруулалт, барилга, байгууламжийн ажилд захиалагчийн чиг үүрэг гүйцэтгэж, хяналт тавих эрхлэх үйл ажиллагааг ийнээр бүртгэв.	2017.11.06	П.Болормаа
4	Жадамба овогтой Баттөгс-а Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.01.08	Б.Болдбаяр

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хувийн үй.



* 0 0 0 1 2 7 4 1 7 *



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 121

Зуунмод

Үйлдвэрийн газрыг өргөтгөж,
дүрэм батлах тухай

Аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын өргөн мэдүүлсэн “Үйлдвэрийн газрыг өргөтгөж, дүрэм батлах тухай” саналыг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн орон тоо нь бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах, зураг төсөв, техникийн норм дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгаж баталгаажуулах, барилга байгууламжийн ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх, барилга байгууламжийг чанартайгаар ашиглалтанд оруулах ажлуудыг шаардлагын хэмжээнд хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна. Үүнээс шалтгаалан зураг төсөвгүй ажил төлөвлөгдөх, барилгын ажлын чанарт тавих хяналт сулрах зэрэг дутагдал гарч байна.

Эдгээр дутагдлыг засаж, ажил сайжруулах зорилгоор аймгийн барилга захиалагчийн ажлын албыг шинээр байгуулан “Төв аймгийн Орон Сууцны Корпораци” ОНӨААТҮГ-т нэгтгэн “Төв аймгийн Барилга захиалагч, Орон Сууцны Корпораци ОНӨААТҮГ” болгон өөрчлөн зохион байгуулах тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын саналыг дэмжиж, “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.7, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 2.4, 4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Барилга захиалагчийн албыг байгуулан “Төв аймгийн Орон Сууцны Корпораци” ОНӨААТҮГ-т нэгтгэн “Төв аймгийн Барилга захиалагч, Орон Сууцны Корпораци орон нутгийн өмчит өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/” болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. “Төв аймгийн барилга захиалагч, Орон Сууцны Корпораци /ОНӨААТҮГ/-ын дүрэм”-ийг хавсралтын ёсоор баталсугай.

3. “Төв аймгийн Барилга захиалагч Орон Сууцны Корпораци /ОНӨААТҮГ/”-ын “Удирдах зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

0100121

Дарга:

Д.Мөнхбаатар

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Д.Алтансүх

-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга, хот
байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Ж.Баттөгс

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгч

Д.Батжаргал

-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Б.Оюунцэцэг

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

4. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, орон нутгийн өмчийн төлөөлөгчдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-д даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулан, удирдах зөвлөлийг нь томилох тухай” 62 дугаар тогтоолыг 3, 4, 5 дугар заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Э.Доржсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 30-ний
өдрийн 121 дүгээр тогтоолын хавсралт

**“ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ, ОРОН СУУЦНЫ
КОРПОРАЦИ” ОНӨААТҮГ-ЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1 “Төв аймгийн барилга захиалагч орон сууцны корпораци” орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах чанартай материал хийц эдлэлээр барилгыг бариулах, зураг төсөв, техникийн норм дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгаж баталгаажуулах, барилга байгууламжийн гүйцэтгэгч байгууллагаас гаргасан зөрчил дутагдлыг засуулах ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх, барилга байгууламжийг чанартай ашиглалтанд оруулахад техникийн хяналт тавихаас гадна холбогдох байгууллага, аж ахуй нэгжтэй ерөнхий захиалагчийн өмнөөс үйл ажиллагааг уялдуулан зохицуулаж, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого, стратеги, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, Зуунмод хотын газрын нөөцийг үр ашигтай төлөвлөн эргэлтэнд оруулах замаар хотын суурьшлын бүсийг хөгжүүлэх, бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах, орон сууцны нөхцлийг сайжруулах, орон сууц нийлүүлэх, ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах зэрэг аймгийн орон сууц, дахин төлөвлөлтийн асуудлыг нэгтгэн зохион байгуулах үүрэг бүхий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн.

1.2 “Төв аймгийн барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ (цаашид “Үйлдвэрийн газар” гэх) үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хууль, Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Барилга захиалагчийн дүрэм, аймгийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, бусад холбогдох хууль, тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3 Энэхүү дүрмийн зорилго нь үйлдвэрийн газрын удирдлага, зохион байгуулалт бүтэц, хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүргийг тогтоох, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэхтэй холбогдох болон бусад үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4 Үйлдвэрийн газрын өмчлөгч нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга болон үйлдвэрийн газрын Удирдах зөвлөл байна.

Хоёр. Газрын хэлбэр, оноосон нэр, оршин байгаа газар:

2.1 Үйлдвэрийн газрын оноосон бүтэн нэр нь “Төв аймгийн Барилга Захиалагч Орон Сууцны Корпораци” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байх бөгөөд товчилсон нэр нь “ТАБЗОСК” ОНӨААТҮГ байна.

2.2 Үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь түүний удирдлага байрлаж байгаа хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг үйлдвэрийн газрын удирдлага тухай бүрт нь улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.3 Үйлдвэрийн газар нь өөрийн бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэнэ. Тамгаар корпорацийн албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлэлцээрийг баталгаажуулна.

2.4 Бэлгэдэл, тэмдгийн загварыг Удирдах зөвлөл баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг Үйлдвэрийн газар эдлэнэ.

2.5 Үйлдвэрийн газрын удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээд тамга, тэмдгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт:

3.1 Үйлдвэрийн газар нь Удирдах зөвлөлтэй байх /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ бөгөөд Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад эрх зүйн актад заасан эрх, үүргийн хүрээнд орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэн, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

3.2 Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Удирдах зөвлөл батлах бөгөөд энэ хязгаарт багтаан ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль, тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх эрхийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

3.3 Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдана. Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулиудад заасан шалгуурыг хангасан байна.

3.4 Үйлдвэрийн газар нь санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг Удирдах зөвлөл батална.

3.5 Үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа иргэд олон нийтэд түргэн, шуурхай хүргэх зорилгоор иргэдэд үйлчлэх салбар, төслийн нэгжтэй байж болно.

3.6 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, ажлаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэрэг асуудлыг Аймгийн Засаг даргатай байгуулах контрактад тусгана.

3.7 Гүйцэтгэх захирлыг эзгүй байх хугацаанд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан тушаалтныг томилж, баталгаажуулна.

Дөрөв. Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

4.1 Үйлдвэрийн газар нь аймгийн орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах, аймгаас зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах ажлыг нэгтгэн зохион байгуулах чиг үүргийн хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.

4.1.1 Аймгийн хэмжээнд орон сууцыг хөгжүүлэхэд эрх зүйн орчныг бүрдүүлэх, орон сууцны талаар баримтлах бодлого, төлөвлөгөө боловсруулахад санал, төсөл боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх

4.1.2 Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хорооллын нэгдсэн, хэсэгчилсэн, ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны бодлого хэрэгжүүлэх

4.1.3 Аймгийн харъяа төрийн байгууллагуудын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа орон сууцны төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах

4.1.4 Аймгийн өмнөөс аймгийн нутаг дэвсгэр дээр орон сууц барих, худалдан борлуулах

4.1.5 Орон нутгийн өмчлөлийн орон сууцны санг хууль, журмын дагуу бүрдүүлж, түүний эзэмшил ашиглалт /түрээслүүлэх, иргэдэд эзэмшүүлэх/, менежментийг хэрэгжүүлэх

4.1.6 Ажил гүйцэтгэгчийг аймгийн Орон нутгийн өмчийн газар болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сонгон шалгаруулах

4.1.7 Үйлдвэрийн газрын захиалан бариулах орон сууцны хотхон, хорооллын инженерийн шугам сүлжээний дэд бүтцийг шинээр бариулах, шинэчлэн сайжруулах, захиалагчийн үүрэг гүйцэтгэж, хяналт тавих

4.1.8 Үйлдвэрийн газрын захиалан бариулсан орон сууцны хотхон, хороолол, цогцоор нь барьсан арилжааны зориулалттай барилга байгууламж, талбайг ашиг олох зорилгоор түрээслүүлэх, худалдан борлуулах

4.1.9 Орон сууцны зориулалттай газрыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн эзэмших, ашиглах,

4.1.10 Орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ захиалагчийн эрх, үүрэг гүйцэтгэх, иргэдийн газар чөлөөлөх, солих, нөхцөл сайжруулах гэрээг байгуулах

4.1.11 Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг шинээр барих, шинэ суурьшлыг бүсийг төлөвлөх

4.1.12 Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах ажлын үүднээс гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын судалгаа, төслийг хэрэгжүүлэх боломж, үндэслэлийг судлах, техник, эдийн засгийн үндэслэл, төсвийн төслийг хэрэгжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх

4.1.13 Аймгаас зорилтот бүлгийг орон сууцаар хангах ажлын хүрээнд хэрэгжүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгийн бодлогыг зохион байгуулах

4.1.14 Иргэд, олон нийтэд Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, орон сууцны талаарх нэгдсэн мэдээллийг хүргэх, сурталчлах

4.1.15 Оршин суугчдын санаачилсан газар дахин зохион байгуулах, дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг дэмжих

4.2 Үйлдвэрийн газар нь улсын болон орон нутгийн төсвийн, хувийн хөрөнгө оруулалт, төрийн оролцоотой хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх барилга, байгууламжийн ажилд захиалагчийн чиг үүрэг, хяналт хийх чиглэлээр дараахи үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна хувийн хөрөнгө оруулалтаар баригдах, орон сууц, олон нийтийн барилга байгууламжинд захиалагчийн хяналтын гэрээг заавал хийж үүрэг хүлээж ажиллана.

4.2.1 Ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах, барилга, зам, инженерийн шугам сүлжээний угсралт, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажлын зураг төслийн даалгавар боловсруулах, зураг төсөв захиалах түүнд хяналт хийх, холбогдох байгууллагуудын зөвшөөрөл авах ажлыг гүйцэтгэнэ.

4.2.2 Үндсэн даацын хийцээс бусад хийц элементийн засварын ажлын зураг төсвийг боловсруулан батлуулахаас гадна холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсны үндсэн дээр барилгын ажлын зураг төсөв хийж болно.

4.2.3 Үйлдвэрийн газар нь гэрээ байгуулах эрх олгогдсон аж ахуйн нэгж, байгууллагатай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан аймгийн Засаг даргаар батлуулна.

4.2.4 Зургийн техникийн даалгавараас зөрүүтэй боловсруулсан зураг төсөл, техникийн шаардлага хангаагүй машин механизм тоног төхөөрөмж материалыг хүлээж авах, ажиллуулахаас татгалзана.

4.2.5 Барилгын тухай хууль тогтоомж, норм дүрэм, стандарт, батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл зөрчсөн барилга байгууламжийн ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааг нь зөрчлийг арилгуулах хүртэл хугацаанд зогсоох арга хэмжээг хууль хяналтын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.2.6 Барилгын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон туршилт тохируулга хийсэн акт холбогдох бусад баримт бичгийг гүйцэтгэгчээс гаргуулан авч түүнийг баталгаажуулан ажиллана.

4.2.7 Гүйцэтгэгчээс барилгын ажил гүйцэтгэх явцад зураг төсөл норм дүрэм, стандарт техникийн нөхцөл зөрчсөн, ажил үйлчилгээгээ чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, төлүүлэх шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийг зогсоох арга хэмжээ авна.

4.2.8 Зураг төслөөр дамжуулан барилгын үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи, материал бүтээцийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааг шинээр нэвтрүүлэх талаар санаачлага гарган ажиллана.

4.2.9 Барилгын үйлдвэрлэлд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.

4.2.10 Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх, далдлагдах ажлыг бүртгүүлэхээс өмнө заавал биечлэн үзэж актыг баталгаажуулах

4.3 Үйлдвэрийн газар нь үндсэн үйл ажиллагааны зорилгод нийцсэн, хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

4.4 Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэхээр бол холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхлэх

4.5 Хууль болон энэхүү дүрэмд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйлдвэрийн газар нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

Тав. Үйлдвэрийн газрын эрх, үүрэг:

5.1 Үйлдвэрийн газрын Удирдах зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй байна.

5.1.1 Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэн, гүйцэтгэх захирлыг улирдлага, арга зүйгээр хангах

5.1.2 Аймгаас иргэдийг орон сууцжуулах талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх, орон сууц, дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, зохицуулах

5.1.3 Орон сууцны салбарт оролцогч талуудын оролцоог жигд хангаж, төр хувийн хэвшлийн түншлэл, иргэдийн оролцоог дэмжих

5.1.4 Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, хөдөлмөрийн норм, норматив, цалин хөлсний бүдүүвчийг тогтоох

5.1.5 Үйлдвэрийн газарт үндсэн хөрөнгө олж авах, хөрөнгийг түрээслэх, актлах, устгах асуудлыг хэлэлцэж зохих журмын дагуу шийдвэрлэх

5.1.6 Худалдах болон түрээслэх орон сууцны м²-ын үнийн тооцоо судалгааг хийж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх

5.1.7 Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилт, үндсэн чиглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Орон нутгийн өмчийн газарт тайлагнах

5.1.8 Аймгийн Засаг даргын тамгын газар, нутгийн захиргааны холбогдох мэргэжлийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулах, хамтран ажиллах

5.1.9 Гүйцэтгэх захирлын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх

5.1.10 Удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв батлах

5.1.11 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулахад шаардагдах тухайн жилийн орлого, зардлын хэмжээ, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтыг батлан, контрактын зорилтот түвшинд тусгуулж хэрэгжүүлэх

5.1.12 Хууль, тогтоомжоор олгосон бусад эрх

5.2 Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал нь дараах эрх, үүрэгтэй байна.

5.2.1 Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан эрх, хэмжээний хүрээнд тушаал гаргах

5.2.2 Баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль, тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх, халах

5.2.3 Гэрээгээр олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх

5.2.4 Үйлдвэрийн газрын бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах

5.2.5 Үйлдвэрийн газрын эрх, ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах

5.2.6 Аймгийн Засаг даргатай байгуулсан контрактын гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн, аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх.

5.2.7 Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад үүрэг

Зургаа. Үйлдвэрийн газрын санхүүжилт, эд хөрөнгийн талаар эрх, үүрэг:

6.1 Үйлдвэрийн газар нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

6.1.1 Аймгийн орон нутгийн өмчлөлийн орон сууцны хувьчлалаас орсон орлого

6.1.2 Түрээсийн орон сууцны орлого

6.1.3 Үйлдвэрийн газрын хариуцан барьж борлуулах орон сууц барих газрын дуудлага худалдааны орлогын 30 хувь

6.1.4 Орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, буцалтгүй тусламж

6.1.5 Үйлдвэрийн газрын ашгаас санхүүжилтэд зориулан хуваарилсан хөрөнгө

6.1.6 Үйлдвэрийн газрын хэрэгжүүлэх тодорхой төслийг санхүүжүүлэхэд зориулан улс болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө

6.1.7 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, барилгын ажлын техник хяналтын зардал

6.1.8 Хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилгын ажлын техник хяналтын зардал

6.1.9 Боловсруулсан барилгын болон засварын ажлын төсөвт өртгийн 2-4 хувийн шимэтгэл

6.1.10 Хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

6.2 Гүйцэтгэх захирал нь үйлдвэрийн газрын эд хөрөнгийг энэ дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах бөгөөд контрактаар олгосон эрх, хэмжээний хүрээнд захиран зарцуулна.

6.3 Үйлдвэрийн газар нь өөрийн өмчийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг өмчлөгч болон Орон нутгийн өмчийн газрын өмнө хариуцаж ажиллана.

6.4 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заасан татвар, хураамжийг төлсний дараах цэвэр ашгаас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосны дагуу ногдол ашгийг холбогдох журмын дагуу төсөвт төвлөрүүлж, үлдэх хэсгийг зохих журмын дагуу захиран зарцуулна.

6.5 Санхүүгийн эх үүсвэр, зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах бөгөөд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт нь олон нийтэд ил, тод байна.

6.6 Үйлдвэрийн газрын удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгийг олж авах, балансад бүртгэх, данснаас хасах, худалдан борлуулах, актлах, шилжүүлэх үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлнэ.

6.7 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалт ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт тавьж ажиллана.

6.8 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг ерөнхий нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

6.9 Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

6.10 Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

6.11 Үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулж болно.

6.12 Хууль, тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх, үүрэг

Долоо. Хариуцлага:

7.1 Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал болон ажилтнууд дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан болон буруутай үйлдэл нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.2 Гүйцэтгэх захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагад хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

Найм. Бусад:

8.1 Үйлдвэрийн газрыг аймгийн Засаг даргын саналаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчид үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

8.2 Энэхүү дүрэм нь Улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.3 Энэхүү дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

___оОо___



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 13

Зуунмод сум

**Удирдах зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай**

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн, “Төв аймгийн Барилга захиалагч, Орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын “Удирдах зөвлөл”-ийг шинэчлэн байгуулах тухай саналыг хэлэлцээд “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.4, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 6 дугаар хуралдааны “Журам шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.4, 4.5.2, 4.5.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Төв аймгийн Барилга захиалагч, Орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын “Удирдах зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчилэн байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

-Аймгийн Засаг даргын орлогч /Төсөв, санхүү, дэд бүтэц, үйлдвэрлэл, ХАА, байгаль орчны салбар хариуцсан/

Гишүүд:

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
-Орон нутгийн өмчийн газрын дарга
-ГХБХБГ-ын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий архитектор
-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

2. Холбогдох хууль, тогтоомж дүрэм журамд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, “Төв аймгийн Барилга захиалагч, Орон сууцны Корпораци” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг удирдлага, менежментээр ханган хэрэгжилтэд хяналт тавьж, ажлыг эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэн ажиллахыг удирдах зөвлөлд даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Үйлдвэрийн газрыг өргөтгөж, дүрэм батлах тухай” 121 тоот тогтоолын 3 заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Ч.Жавзанпагма/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЖАМБАЛСҮРЭН





**ТӨВ АЙМГИЙН
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОРОН
НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 01

Зуунмод

2022 оны үйл ажиллагаа, 2023 оны төсөв
батлах тухай

Компаний тухай хуулийн 76-р зүйлийн 1.2 дах заалт, 76-р зүйлийн 1.11 дах заалт, Барилга захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-н төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 06-ны өдрийн хуралдааныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Барилга захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Барилга захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллаганы орлогыг 329 сая төгрөгөөр хавсралт №1-р, үйл ажиллагааны зардлыг 319 сая төгрөгөөр хавсралт №2-р тус тус баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гаргасан санал зөвлөмжийг хэрэгжүүлж, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг захирал (Ж.Баттөгс)-д үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.СУРМАА

ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-ЫН
2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ

ҮЗҮҮЛЭЛТ	3271185-4117252759 2023 оны төсвийн төсөл	Санхүүжилтийн эх үүсвэр
I. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН /урсгал зардал+ХО зардал/	319,046,515	2023 оны захиалагчийн хяналтын орлогоос
II. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	319,046,515	
Бараа үйлчилгээний зардал	319,046,515	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,651,218	
Үндсэн цалин	210,651,218	
Нэмэгдэл урамшил		
Унаа хоолны хөнгөлөлт		
Гэрээт цалин		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,331,402	
Тэтгэвэрийн даатгал	17,905,354	
Тэтгэмжийн даатгал	2,106,512	
ҮОМШ өвчний даатгал	1,685,210	
Ажилгүйдлийн даатгал	421,302	
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	4,213,024	
Байгууллагын тогтмол зардал	1,020,000	
Цэвэр, бохир ус	240,000	
Гэрэл цахилгаан	180,000	
Түлш, халаалт	600,000	
Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	32,944,920	
Тээвэр (шатахуун)	19,923,120	
Шуудан, холбоо	1,360,800	
Бичиг хэрэг	3,536,000	
Ном, хэвлэл авах	325,000	
Эрүүл мэнд, Тэтгэмж	7,800,000	
Эд хогшлын зардал	12,220,000	
Эд хогшил худалдан авах	10,100,000	
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах	2,120,000	
Томилолт зочны зардал	19,522,000	
Дотоод албан томилолт	15,562,000	
Хичээл, сургалт, семинар, хурал, зочны зардал	3,960,000	
Бараа үйлчилгээний бусад зардал	16,356,975	
Техникийн нөхцөл, магадлал	5,090,400	
Аудитын зэрэглэл тогтоох үйлч.хөлс	588,000	
Газрын төлбөр	3,603,575	
Тээврийн хэрэгслийн зардал	3,235,000	
Зар сурталчилгааны зардал	3,740,000	
Дансны шимтгэл	100,000	
УРСГАЛ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
Техник хяналтын орлого	329,071,516	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, ҮР ДҮН	10,025,001	
ТЗ-ны 2-р байрны гадна фасад засварын ажил	20,000,000	Захиалагчийн хяналтын өмнөх оны хуримтлагдсан орлогоос
Орон нутгийн өмчийн дотор сангийн засварын ажил	20,000,000	
БЗОСК-ын байрны дотор тохижилтын ажил	20,000,000	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	
АЖИЛЛАГСАД БҮГД	12	
Удирдах ажилтан	1	
Гүйцэтгэх ажилтан	9	
Үйлчлэх ажилтан	2	

Хянасан/Захирал /Ж.Баттөгс/

Төлөвлөгөө гаргасан/ Ня-Бо Ж.Чинзориг

ТӨВ АЙМГИЙН

БЗОС Корпораци ОНӨААТҮГ-Н ТҮЗ-ЫН 2023 ОНЫ 01 САРЫН
10-НЫ ӨДРИЙН 01-ТООТ ТОГТООЛЫН 1-Р ХАВСРАЛТ

БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ
ХАРИУЦАЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл	Хэрэгжэх хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	2023 онд санхүүжих дүнгээс тооцсон ЗХ
			Эхлэх	Дуусах			
1	2	3	4	5	6	7	
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /Он дамжсан/							
1	Спортын төрөлжсөн сургуулийн барилга, 640 суудал /Төв, Зуунмод сум/	Ажил	2019	2022	5,002.6	516,225,690.0	7,743,385
2	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Заамар сум/	Ажил	2020	2021	1,500.0	140,079,405.0	2,101,191
3	Соёл, спортын төвийн барилга /Төв, Баянжаргалан сум/	Ажил	2020	2021	1,200.0	885,779,536.0	13,286,693
4	Соёл, спортын төвийн барилга /Төв, Борнуур сум/	Ажил	2020	2021	2,000.0	130,527,056.0	1,957,906
5	Соёл, спортын төвийн барилга /Төв, Сэргэлэн сум/	Ажил	2020	2021	1,200.0	67,585,576.0	1,013,784
6	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Заамар сум, Хайлааст баг/	Ажил	2021	2022	2,865.1	391,866,519.00	5,877,998
7	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Төв, Эрдэнэсант сум/	Ажил	2020	2024	1096.2	386,955,138.0	5,804,327
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Лүн сум/	Ажил	2021	2022	1500	189,841,511.0	2,847,623
9	Цэцэрлэгийн барилга /Төв, Утгаалцайдам сум/	Ажил	2021	2022	1300	128,240,294.0	1,923,604
10	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Баянцогт сум/	Ажил	2021	2023	1798.1	204,718,478.0	3,070,777
11	Дотуур байрны барилга буулгаж, шивээр барих, 160 ор /Төв, Бүрэн сум, 1 дүгээр баг/	Ажил	2022	2023	3,351,000,000	3,130,800,000	46,962,000
12	Дотуур байрны барилга, 160 ор /Төв, Зуунмод сум, 1 дүгээр баг/	Ажил	2022	2023	2,100,000,000	1,675,600,000	25,134,000
13	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Жаргалант сум/	Ажил	2022	2023	1,500,000,000	1,299,700,000	19,495,500
Улсын төсвийн хөрөнгө оруулалт нийт дүн					6,951,019,462	9,147,919,203	137,218,788
АЙМГИЙН ТӨСВИЙН ШИЛЖИХ ҮЛДЭГДЛИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ							
1	Баянхошуу чиглэлийн автозамын шивэгчлэлийн ажил /Зуунмод/	Ажил	2022	2023	500,000,000	500,000,000	7,100,000
2	Манжушпырын амны төлбөр хурах цэг, авто зогсоол байгуулах ажил	Ажил	2022	2023	350,000,000	46,809,778	70,215
Шилжих үлдэгдлийн дүн					850,000,000	546,809,778	7,170,215
АЙМГИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ							
1	Төвийн авто зам дагуу явган хүний зам барилгын ажил	Ажил	2022	2023	400,000,000	202,134,187	3,032,013
2	Улс, орон нутгийн чанартай авто замын тэмдэгжүүлэлт	Бараа	2023	2023	20,000,000	20,000,000	300,000
3	Авто замын засвар, өвөл зуны арчлалтын ажил /Зуунмод/	Ажил	2023	2023	200,000,000	200,000,000	5,600,000
4	Авто замын засвар арчлалтын ажил /Борнуур, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Алтанбулаг, Эрдэнэсант/	Ажил	2023	2023	77,000,000	77,000,000	2,156,000
ЗАМЫН САНГИЙН ДҮН					697,000,000	499,134,187	11,088,013
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ							
1	Мөнх-Алдын талбайг шивэгчлэн засварлах	Ажил	2023	2023	400,000,000	400,000,000	6,000,000
2	Сумын төвийн гэрэлтүүлэг тохиожил төсөл /Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр/	Ажил	2023	2023	480,000,000	480,000,000	7,200,000
3	Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл	Ажил	2023	2023	1,000,000,000	1,000,000,000	15,000,000
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ДҮН					1,880,000,000	1,880,000,000	28,200,000
ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НИЙТ ДҮН					3,427,000,000	2,925,943,965	107,852,727
22	Нийт дүн /Улс болон орон нутгийн хөрөнгө оруулалт/				10,378,019,462	12,073,863,168	245,071,516

БЗОСК Орлогын төлөвлөгөө	Ажлын тоо	2023 онд санхүүжих дүн	
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	13	9,147,919,203	137,218,788
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	9	2,925,943,965	107,852,727
Орон сууцны барилга			84,000,000.0
Нийт	22	12,073,863,168	329,071,516

Хянасан: Зарцрал

Жагсаалт гаргасан: НаБо

Ж.Баттөгс

Ж.Чинзориг



**СУМДАД 2023 ОНД ЭРХ ШИЛЖҮҮЛЖ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ
(ЗУРАГ ТӨСӨВ, АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ)-Г
ХАРИУЦАН БОЛОВСРУУЛЖ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ ЗАХИАЛАГЧ**

Д/д	Төслийн нэр, хүчин чадал	Хугацаа		Төсөвт өртөг /төг/	Санхүүжих дүн /төг/	
		Эхлэх	Дуусах			
АЙМГИЙН ЗАМЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР						
1	Зуунмод сумын дотор замын их засвар	2023	2023	100,000,000	100,000,000	2,800,000
2	Борнуур сумын дотор замын их засвар	2023	2023	100,000,000	100,000,000	2,800,000
3	Эрдэнэ сумын дотор замын их засвар	2023	2023	200,000,000	200,000,000	5,600,000
ДҮН				400,000,000	400,000,000	11,200,000
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР						
1. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ						
1	Эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэгч /Батсүмбэр Цогт өндөр баг/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
2	Сумын төвийн гэрэлтүүлэг шинэчлэл /Мөнгөнморьт сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
3	Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасадын ажил /Зуунмод 16, 17 байр/	2023	2023	210,000,000	210,000,000	3,150,000
4	Зуунмод сумын Нацагдорж багийн эрчим хүчний сүлжээний өргөтгөл их засвар өргөтгөл	2023	2023	50,000,000	50,000,000	750,000
5	Зуунмод сумын Зүүндэлгэр багийн хүчдэлийн уналттай өрхийн 0.4кВ-ын ЦДАШ-ын өргөтгөл	2023	2023	44,000,000	44,000,000	660,000
6	Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Баянхангай сум/	2023	2023	80,000,000	80,000,000	1,200,000
7	Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Дэлгэрхаан сум/	2023	2023	80,000,000	80,000,000	1,200,000
8	Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Мөнгөнморьт сум/	2023	2023	80,000,000	80,000,000	1,200,000
9	Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Баяндэлгэр сум/	2023	2023	80,000,000	80,000,000	1,200,000
10	Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох /Баянжаргалан сум/	2023	2023	80,000,000	80,000,000	1,200,000
ДҮН				904,000,000	904,000,000	13,560,000
2. ШИНЭЭР ХИЙГДЭХ ИХ ЗАСВАРЫН АЖЛУУД						
1	Эрүүл мэндийн төвийн их засвар /Бүрэн сум/	2023	2023	250,000,000	250,000,000	3,750,000
2	Эрүүл мэндийн төвийн их засвар /Борнуур сум/	2023	2023	70,000,000	70,000,000	1,050,000
ДҮН				320,000,000	320,000,000	4,800,000
3. БУСАД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖИЛ						
1	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Баяндэлгэр сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
2	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Баян-Өнжүүл сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
3	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Баянцагаан сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
4	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Баянцогт сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
5	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Заамар сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
6	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Лүн сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
7	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Угтаалцайдам сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
8	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Цээл сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
9	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Эрдэнэ сум/	2023	2023	60,000,000	60,000,000	900,000
10	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Баян сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
11	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Баяндэлгэр сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
12	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Эрдэнэсэнт сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
13	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Баян-Өнжүүл сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
14	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Сүмбэр сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
15	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Лүн сум/	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
ДҮН				1,140,000,000	1,140,000,000	17,100,000
АЙМГИЙН ОНХСАНГИЙН ДҮН				2,364,000,000	2,364,000,000	35,460,000
АЙМГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2023 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭР						
1	Эрдэнэсэнт сумын Соёлын төвийн их засвар	2023	2023	492,300,000	492,300,000	7,384,500
2	Борнуур сумын цэцэрлэгийн их засвар	2023	2023	100,000,000	100,000,000	1,500,000
3	Сэргэлэн сумын Дунд сургуулийн барилгын их засвар	2023	2023	200,000,000	200,000,000	3,000,000
4	Баянцагаан сумын ЗДТГазрын байрны их засвар	2023	2023	110,000,000	110,000,000	1,650,000
5	Баян-Өнжүүл сумын ЗДТГазрын өргөтгөл	2023	2023	80,000,000	80,000,000	1,200,000
ДҮН				982,300,000	982,300,000	14,734,500
ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН НИЙТ ДҮН				3,746,300,000	3,746,300,000	61,394,500